

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭД БҮРТГЭЛИЙН ДЭВТЭР ХӨТЛӨХ, ТАЙЛАН, МЭДЭЭ ИРҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журам нь Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн болон барьцаа хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, үйл ажиллагаанд хяналт тавих холбогдох эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцох, Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс ирүүлэх тайлан мэдээг авах, үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээлэл солилцохтой холбогдох харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь өөрийн үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэх, хяналт тавин удирдах зорилгоор Хорооноос тогтоосон мэдээ тайлангаас гадна бусад хэм хэмжээг холбогдох хууль, журамд нийцүүлэн боловсруулж, дотооддоо мөрдүүлж болно.

ХОЁР. БҮРТГЭЛИЙН ДЭВТЭР ХӨТЛӨХ

- 2.1. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь олгосон зээлийн болон барьцаа хөрөнгийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан энэхүү журмын Хавсралт 1-ээр баталсан Бүртгэлийн дэвтрийг цаасан хэлбэрээр, Хавсралт 2-оор баталсан мэдээллийг багтаасан бүртгэлийн системийг цахим хэлбэрээр өдөр тутмын үйл ажиллагаандаа заавал хөтөлнө.
- 2.2. Бүртгэлийн дэвтэрт заасан зурган хэлбэрийн мэдээллийг цахимаар заавал оруулна. Хавсаргах зурган мэдээлэл нь дараах шаардлагыг хангасан байна.
 - 2.2.1. Иргэний үнэмлэхийг бүтэн, ар, өвөргүй тод, гаргацтай өнгөтөөр сканердаж PDF өргөтгөлөөр оруулна.
 - 2.2.2. Барьцаа хөрөнгийн зургийг авахдаа бүтэн, тод, гаргацтай тухайн барьцаа хөрөнгийг илэрхийлэх загвар, марк, дугаар, жинг харуулсан байдлаар авч системд оруулна.
- 2.3. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээд Хавсралт 2-оор баталсан загвар маягтын дагуу цахим мэдээллийн санг бүрдүүлж, Санхүүгийн зохицуулах хорооны нэгдсэн мэдээллийн санд нийлүүлэх үүрэгтэй.
- 2.4. Мөнгөн зээлийн үйлчилгээ эрхлэх этгээдүүдийн цахим Бүртгэлийн дэвтрийн нэгдсэн мэдээллийн сан Санхүүгийн зохицуулах хороонд байршина.
- 2.5. Энэхүү журмын 2.6-д заасан нэгдсэн мэдээллийн санд Санхүүгийн зохицуулах хороотой хамтран ажиллах гэрээ байгуулсан хууль хяналтын байгууллагын холбогдох албан хаагч нэвтэрнэ.
- 2.6. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээд нь

ГУРАВ. МЭДЭЭ, ТАЙЛАН

- 3.1. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд дараах тайланг хагас, бүтэн жилээр өссөн дүнгээр гаргаж, дараа сарын 20-ны өдрийн дотор харьяалах бүртгэх байгууллагад цахимаар ирүүлнэ.
 - 3.1.1. Зээлийн нэгдсэн тайлан /Хавсралт 3/
 - 3.1.2. Хураангуй тайлан /Хавсралт 4/
 - 3.1.3. Үүрэг гүйцэтгэсэн зээлийн мэдээ /Хавсралт 5/

3.1.4. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон шаардлагатай бусад мэдээлэл.

ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА

4.1. Хагас, бүтэн жилийн мэдээ, тайланд харьяалах бүртгэх байгууллага хяналт тавьж, шаардлагатай гэж үзвэл газар дээр нь шалгалт хийнэ.

4.2. Тайлан, мэдээг хугацаандаа ирүүлээгүй тохиолдолд “Мөнгөн зээлийн үйл ажиллагааг эрхлэх этгээдийг бүртгэх, түүнд хяналт тавих журамд”-д заасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.3. Бүртгэлийн дэвтэрт санаатай болон санаандгүй байдлаар буруу мэдээлэл оруулсан тохиолдолд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасны дагуу арга хэмжээ авна.

4.4. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

0000/СС/ӨӨ

/төгрөгөөр/

ХӨРӨНГӨ		ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	
1.ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		1. ӨР ТӨЛБӨР	
1.1	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1.1	ЗЭЭЛ
	Бэлэн мөнгө		Банкнаас авсан зээл
	Харилцахад байршуулсан		Зохицуулалттай хуулийн этгээдээс авсан зээл
	Хадгаламжид байршуулсан		Зохицуулалттай хувь хүнээс авсан зээл
1.2	НИЙТ ЗЭЭЛ	1.2	ГАРГАСАН ӨРИЙН БИЧИГ
	Хугацаандаа байгаа (20 хүртэлх хоног хугацаа хэтэрсэн)	1.3	БУСАД ӨР ТӨЛБӨР
	Хугацаа хэтэрсэн (21-ээс дээш хоног хугацаа хэтэрсэн)	2. ЭЗДИЙН ӨМЧ	
1.3	ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨ	2.1	ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ
1.4	БУСАД ХӨРӨНГӨ	2.2	ХУРИМТЛАГДСАН АШИГ/АЛДАГДАЛ
2. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			Тухайн үеийн ашиг/алдагдал
2.1	ҮНДСЭН (БИЕТ) БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)		Хуримтлагдсан ашиг/алдагдал
	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө		
	(Хуримтлагдсан элэгдэл)		
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	
ЗАРДАЛ		ОРЛОГО	
	Цалингийн зардал		Зээлийн хүүгийн орлого
	Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зардал		Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого
	Үйл ажиллагааны зардал		Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого
	Түрээсийн зардал		Нэмэгдүүлсэн хүүгийн орлого
	Бусад зардал		Харилцах, хадгаламжийн хүүгийн орлого
	Орлогын албан татварын зардал		Бусад хүүгийн орлого
			Бусад орлого
		ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	
			Зээлийн ҮНДСЭН төлбөрт хүлээн авсан мөнгөн дүн
			Зээлийн ХҮҮГИЙН төлбөрт хүлээн авсан мөнгөн дүн
			Барьцаа хөрөнгө борлуулснаас хүлээн авсан мөнгөн дүн

